

**МЭРГЭН ГЭГЭЭН ЛУВСАНДАМБИЙЖАЛЦАНЫ ОРЧУУЛСАН  
СУБАШИДЫН ҮГИЙН САНГИЙН ЗАРИМ ОНЦЛОГООС**

О. Дэмчигмаа\*

13 дугаар зууны эхэн үеэр Төвдийн Сажа бандида Гунгаажалцаны зохиосон “Сайн номлолт эрдэнийн сан” буюу санскрит нэрээрээ “Субашид” хэмээн алдаршсан иргэний шинж чанартай сургаалын зохиолыг мэдэхгүй хүн Монголд бараг үгүй гэхэд болно. Эл зохиолыг Монголын эрдэмтэн лам нар удаа дараа орчуулсаар Монгол оронд өргөн дэлгэрсэн байх юм.

Өдгөө бидний мэдэж буйгаар бүрэн бүтэн, нийтэд дэлгэрсэн найман орчуулга байхын сацуу судалгааны эргэлтэд орж, олон нийтэд мэдээлэгдээгүй гар бичмэл, хадмал болон аман орчуулгууд, цаашлаад тайлбарын орчуулга ч нэлээд буй. Гэсэн хэдий ч эдгээр орчуулга тус тусдаа нарийн тодорхой судлагдаагүй байсаар байгаа билээ.

Бид энэхүү өгүүлэлдээ Урадын Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны орчуулсан Субашидын үгийн сангийн зарим онцлогоос товч өгүүлэхийг зорилоо.

Орчуулгыг XVIII зууны далаад оны үед Бээжин хотод модон бараар хэвлэсэн байна. *Монгол оронд түгээмэл дэлгэрсэн энэ орчуулга судрын хэлбэртэй. Цаасны хэмжээ нь. 29,5 x 10 см, 78 хуудастай. Эдүгээ Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнд 44.97 16:2 дугаартай хадгалагдаж байна. Төгсгөлд нь орчуулагчийн зохиосон найман бадаг төгсгөлийн үг бий. Уул судрын дээр “1958 онд Мэргэнбаатар гуай авчирсан”<sup>1</sup> гэж бичжээ.*

Үүнээс гадна гар бичмэл орчуулга нэлээд олон байдаг. “...Өвөр Монголын номын санд л гэхэд 01445, 01446 дугаартай хоёр зүйлийн гар бичмэл байна. Эдгээрийг муутуу цаасан дээр үсэн бийрээр бичжээ. Эхний гар бичмэлийн өмнөх нэг хуудас, хойнох хэдэн хуудас нь гээгдсэн бөгөөд дунд нь хэдэн газар тасарчээ. Энэ гар бичмэл 19 см x 22 см хэмжээтэй, үдмэл, гарчгийг нь номын сангаас “Сайн үгт эрдэнийн сан шастир” хэмээн нохож тавьсан нь мэргэн гэгээний орчуулгын гарчигтай зөрж буй. Хоёр дахь гар бичмэл дээрхтэй үндсэндээ адил. 21,5 см x 25 см, үдмэл. Нэлээд бүрэн, гарчиг нь “Сайн үгт эрдэнийн сан субашид хэмээгдэх шастир”, Дамбийжалцаны модон барын хэвлэлийн судрын гарчигтай бараг тохирох юм. Гар бичмэлийг ажиглавал дээрх хоёр гар бичмэлийн тиг нь адилгүй, хоёр өөр хүн бичсэн нь тодорхой байна. Эдгээр гар

\* МУИС-ийн МХСС-ийн багш, докторант

<sup>1</sup> “Сайн үгт эрдэнийн сан нэрт шастир”. Зууннаст, Сэцэнцогт харгуулан тайлбарлав. (1989) Монгол тулгуур бичгийн цуврал. 71 дүгээр тал, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.,

бичмэлийг Бээжин барын хэвлэлээс хуулаагүй бололтой. Модон барын хэвлэлд буруу ташаа зүйл гар бичмэлд нэлээд зөв байх ажээ".<sup>2</sup>

Бичгийн их хүн, академич Ц. Дамдинсүрэн гуайн гэр музейд Бээжин барын судрын нэг хувилбар хадгалагдаж байна. **ШЗ-14. МН-969** дугаартай. 78 хуудастай. Цаасны хэмжээ: 31x10.8 см; Эх бичгийн хэмжээ: 24.7x7.6 см. Хятад цаасан дээр 19 мөрөөр барласан. Эх гарчиг үгүй. Хуудасны захын гарчиг нь Субхашита. Судрын нүүрэн дээр Ц. Дамдинсүрэн гэж бичсэн байна.

Монголын Олимпийн үндэсний хорооны гишүүн Ш. Магван гуай хувийнхаа цуглуулгад байсан хуучин судар номоосоо манай их сургуульд хандивласанд Мэргэн гэгээний модон барын энэ орчуулга байсан нь тэнхимийн маань хөмрөгт хадгалагдах болсон юм. Уг эх Ц. Дамдинсүрэн гуайн гэр музейд буй эхтэй адил юм.

Мөн эдгээртэй яг адил нэгэн эх Монголын Үндэсний Номын Сангийн (цаашид МУНС) монгол номын хөмрөгт хадгалагдаж байна.

Мэргэн гэгээн (1717-1766) “Субашид”-ыг яг хэдэн онд орчуулсан нь тодорхойгүй. Юутай ч 18 дугаар зууны дунд үеийн орчуулга гэдгээрээ шарын шашин Монгол оронд түгэн дэлгэрч, бурханы шашны ном зохиолыг монгол хэлнээ олноор орчуулж байсан тухайн үеийн хэлний онцлог, ялангуяа судар бичгийн хэлний үгийн сан, бичлэг, орчуулгын онцлогийг тусгасан, чухал ач холбогдол бүхий бүтээлүүдийн нэгэн болох буюу.

Уг орчуулгыг бүхэлд нь ажиглахад хэв шинжийн хувьд хэт үгчилсэн ч бус, хэт утгачилсан ч бус ерөнхийдөө төвд эхийнх нь утга санааг хадгалахыг эрхэмлэсэн гэж хэлж болохоор байна. Толгой холбож орчуулсан бадаг маш цөөн хэдий ч хэлзүйн хувиргалыг нэлээд өргөн хэрэглэсний зэрэгцээ өөр бусад онцлог шинжийг агуулсан байгаа юм.

Ингээд орчуулгыг нийтэд нь эрдэм шинжилгээний галигаар буулган нягталж судалсны үндсэн дээр, орчуулга дахь үгсийн сангийн бүрэлдэхүүний харь хэлний болон хуучирсан зарим үгсийг тайлбарлав.<sup>3</sup> Үүнд:

#### **Санскрит гаралтай үгс:**

**Bady-a dhari.** Мөргөлийн шүлэгт тохиолдож буй **Vidyādhara** (Ю.Н. Перих. 1983. 9.70) хэмээх энэхүү санскрит үгийг төвдөөр “*rig ‘dzin gtso- puзун зо*”, монголоор “*ухааныг баригчийн эрхэм*” хэмээнэ. Сономгара, Дана-гийн гэгээн нар мөн дээрх санскрит үгээр, Намхайжамц “*ухаан баригчийн эрхин*”, Сумадираднаа “*арвисыг баригч шидтэн*” гэж орчуулжээ.

**Akṣadar - nakṣatra, ṛkṣa** (Ю.Н.Перих. 1983. 2.258) Энэ санскрит үг 9 дүгээр бадагт буй. Төвдөөр “*rgyu skar - жү гар*”, монголоор “*од*” хэмээх утгатай үгийг “акшадар” гэж орчуулжээ. Сарны зурхайн хорин найман одны нэр. Ю.Н.Перих толь бичигтээ *Созвездие, звезда, constellation, star* гэж тэмдэглэсэн буй. Мэргэн гэгээний орчуулгад “*n*” үсгийн өмнөх цэгийг тавиагүй, цэг тавихгүй үгэнд тавьсан болон “*ṣ*” үсгийн цэгийг өмнө нь тавьсан гэх мэт бичлэгийн онцлогууд нэлээд буйн нэг жишээ энэ үг юм. Сономгара, Зая бандида Намхайжамц нар “*явахуй одон*” гэж үгчлэн

<sup>2</sup> Дээрх ном. 73-74 дүгээр тал.

<sup>3</sup> Өгүүллийн хүрээ хэмжээнд тохируулан цөөн тохиолддог, илүү анхаарал татахуйц зарим үгсийг сонгон авч товч тайлбарыг хийлээ. Толгой үгсийг орчуулга дахь бичлэгийн галигаар авав.

орчуулсан бол Цахар гэвш Лувсанчүлтэм, Сумадираднаа нар “*odod*” хэмээн орчуулсан буй.

**Sakar-a<sup>4</sup>.** Субашидын тус орчуулгын 282 дугаар бадагт тохиолдох энэ үг төвдөөр “*rgya mtsho - жамцо*” буюу монголоор “*далай*” хэмээх утгатай бөгөөд санскритаар *sākara*, (Ю.Н.Перих. 1983. 2.234) **samudra, jalendra** гэдэг байна. Бусад орчуулагч нар бүгд “*далай*” гэж монгол үгээр орчуулжээ.

**zu-a ki.** Төгсгөлийн үгэнд гарч буй энэ санскрит үг төвдөөр “*’tsho byed - цо жэд*”, монголоор “*анагаагч, эмч, оточ*” хэмээх утгатай. Ю.Н.Перихийн толь бичигт яг энэ үгийг санскритаар хадмаллаж бичээгүй байх боловч “*tsho bar gyur cig - цо вар жүр жуц*” буюу “анагаах болтугай” гэх үгийг *jīvaka* (Ю.Н.Перих. 1983.7.319) хэмээсэн нь үндсэндээ тохирох юм. Цахар гэвш Лувсанчүлтэм, Сумадираднаа нар ийн орчуулсан бол Дана-гийн гэгээн “*анагаагч оточ*”, Зая бандида Намхайжамц “*эмч*” гэжээ.

**Binayaka. Vīnāyaka.** (Ю.Н.Перих. 1983. 4-324, 9.210) Төвдөөр “*Log ’dren - лог дэн*” буюу монголоор “*буруу жолоодогч, буруу удирдагч*” гэсэн уг үгийг Сономгара “*дордос*”, Зая бандид “*буруу удирдагч*”, Лувсанчүлтэм “*үтэл адас*” гэж орчуулцгаасан бол Мэргэн гэгээн, Дана-гийн гэгээн, Сумадираднаа нар санскритаар нь “*бинаяка*” хэмээн буулгажээ.

**Enggeske. Kiṃśuka** (Ю.Н.Перих.1983.1-44). 260 дугаар бадагт төвдөөр **king shu** гэж санскрит дуудлагаар нь бичсэн ажээ. Энэтхэгт ургадаг нэгэн зүйлийн мод бөгөөд навч болон үр цэцгүүд ув улаан, давирхайгаар нь энгэсэг будаг хийдэг. Монгол хэлнээ дуудлага нь сунжирч “*энгэсэг*” болжээ.

**Vidar. Vetāla, pramoha.** (Ю.Н.Перих. 1983.9.111). Төвдөөр “*ro langs - ро лан*”, монгол хэлнээ “*ороолон*” хэмээн төвд хэлнээс орсон үг. Үгчлэн буулгавал “*боссон хүүр*” гэсэн утгатай бөгөөд Энэтхэг, Төвдийн домогт гардгаар үхсэн хүний бие, булш модонд орогнодог хортон сүнс гэдэг.

**Diyaṣīlan.** 257 дугаар бадагт буй энэ үг төвд эхдээ “*dka’ thub ldan pa - гаа түв дан ба*”, монголоор “*хатуужил төгөлдөр*” хэмээх үг байх бөгөөд бясалгал, даяаныг төгс хийсэн гэсэн утгатай. Мэргэн гэгээн орчуулахдаа даяан хийх, даяанчлах гэсэн утгаар авсан байна. Тиймийн тул **diyaṣīlan** гэдэг үг бол санскрит хэлний *dhyāna* (Ю.Н.Перих. 1983.10.172), монгол хэлнээ “*даяан*” хэмээн орж ирсэн үгэнд монгол хэлний нэр үгээс нэр үг үүсгэх “-ч” дагавар, нэр үгээс үйл үүсгэх “-л” нөхцөл, түүнчлэн нөхцөлт үйл үгийн “-н” нөхцөл тус тус залгаж үүссэн үг юм.

**Kulti. koṭah** (Ю.Н.Перих.1983.6.231). Төвдөөр “*bye ba - жэ ва*”, монголоор “10 сая”. Хуучны судар номд “колти, голди” гэх мэтээр элбэг тохиолддог.

**Kumbāra. Grāha, kumbhāra** (Ю.Н.Перих.1983.3.104). 205 дугаар бадагт гарах энэхүү санскрит үг түрүү үеийн бичгийн дурсгалуудад тохиолдохгүй бөгөөд бусад орчуулагч нар “*матар*” хэмээн монгол үгээр нь орчуулцгаажээ.

Эдгээрээс гадна монгол хэлнээ эрт дээр үеэс орчуулгаар дамжин орж, өдгөө үгсийн сангийн бүрэлдэхүүн хэсэг болон бараг уугуул шахам болсон санскрит гаралтай үгс нэлээд байна. Тухайлбал, **abiyas** - abhyāsa - goms pa’i<sup>5</sup> - авьяас, **gšan** - kṣana - skad cig - агшин, **baling** - bali - gtor ma - балин, **buyan** - puṇya - bsod nams - буян, **Bhudi** - bhūta - ‘byung po’i bya - бүднэр, элээсийн шувууд, **śastir** - śāstra - bstan bcos - шастир, **sidi** -siddha - grub - шид, **erdeni** - ratna - rin chen - эрдэнэ, **tib** - dvīpa - gling - тив,

<sup>4</sup> Орчуулгад ганц удаа тохиолдож буй.

<sup>5</sup> Төвдөөр **goms pa** буюу дадах, занших хэмээх үгийг “*авьяас*” хэмээн орчуулжээ.

**arasiyan**<sup>6</sup> - rasāyana - bcud len - рашаан, **sala** - sāla - sa\_ 'a la - сала (мод), **sudar**<sup>7</sup> - sūtra - mdo - судар, **Symbьr** - Sumeru - lhun po<sup>8</sup> - Сүмбэр, **ubadis** - upadeśa - gdams ngag - увдис, **čedig** - jātaka - skyes 'phreng - цэдиг гэх мэт. Мөн бурханы шашны холбогдолт үг хэллэг болон оноосон нэрс цөөнгүй тохиолдоно. Дурдвал: **Man...uširi** - mañjuśrī - 'jam dbyangs - Манзушир, **Viśnū** - viṣṇu - gos ser can ('khyab 'jug pa) - Вишнү, **Makišuvāri** - Maheśvara - dbang phyug chen po - Махешвари, **Mahadeb-a** - Mahādeva - lha chen - Махадэва, **Sigemьni** - Śākyamuni - sha\_ 'a kya thub pa - Шагжамуни, **Zakr-a vardi** - Cakravartī - 'khor los 'gyur ba - Чакраварди, **Fa\_ali** - balavat - stobs ldan, **Raqu** - Rāhu - gza'<sup>9</sup> - Раху гэх мэт.

### Төвд гаралтай үгс:

**Ыли.** Энэ үг төвд эх зохиолд (90 дүгээр бадаг) буйгаар “*byi ba - жи ва*” буюу монголоор “*хулгана*” юм. Бусад орчуулагчид бүгд *хулгана* гэж орчуулсан бол Мэргэн гэгээн “иүли” орчуулжээ. Орчуулгын бичлэгт “-н” үсгийн өмнөх цэгийг тавиагүй нь олонтаа гэдгийг дээр дурдсан билээ. Тиймийн тул энэхүү үг бол “*ниүли*” буюу төвд хэлний **Ne'u le** - солонго амьтан, эрдэнийн хулгана, морин хулганыг заасан үг мөн. Толгой бага, нүд жижиг, чих дүгрэг, ам их, хошуу нарийн, хамар нүцгэн, сахал урт, хурц хумс, охор мөч бүхий нэг зүйлийн хөхтөн. Хүзүү бие, сүүл нарийн, ар нь улбар шар, өвөр нь цайвар шар, ойн хөвөө, говь газраар нүхэнд байрлан, шөнө гарч хулгана, оготно, жижиг шувуу, загас, мэлхий зэргээр хооллоно. Модонд авирч усанд умбаж чаддаг, үс арьс нь ховор үнэтэй. Хулгана устгахад ашигтай амьтан<sup>10</sup> юм.

**Sanma.** Субашидын 42 дугаар бадагт тохиолдож буй нэгэн зүйл цэцгийн нэр. Орчуулагч нар өөр өөрөөр орчуулсныг тэмдэглэвэл Сономгара “*сүмэн цэцэг*”, Зая бандида “*самбага цэцэг*”, Дана-гийн гэгээн, Цахар гэвш нар “*задийн цэцэг*”, Сумадираднаа “*цахирмаа цэцэг*” гэх мэтчилэн орчуулцгаажээ. Төвд хэлээр **sna ma** гэх бөгөөд Мэргэн гэгээн төвд дуудлагаар нь буулгасан бололтой.

**Bod grogs.** Вод дог. Монгол хэлнээ үгчлэн буулгавал “*дуудах нөхөр*” хэмээнэ. Эртний Энэтхэгийн алдарт “*Рамаяна*” туулийн арван толгойт мангасын хааны нэр. Сономгара санскритаар нь “*Daś-a-girvī*”, Зая бандида “*Doudan (дуудан) pōkūr*” хэмээн төвдөөс нь шууд үгчилж, Цахар гэвш “*мангас*”, Сумадираднаа “*арван толгойт мангас*” гэж тус тус орчуулжээ. Санскритаар **daśagrīvā**, төвдөөр **mgul bcu - арван хоолойт** гэдэг.

**Samčoy.** 454 дүгээр бадагт тохиолдох энэ үгийг монголоор үгчлэн орчуулбал “*дээд газар*” хэмээсэн утгатай бөгөөд цагаан занданы илт өгүүлэх нэр юм. Ийм төрлийн зандан маш ховор ургадаг, үнэт мод гэдэг. Сономгара “*зандан*”, Цахар гэвш “*Самчог нэрт зандан*” гэж юу болохыг тодотгон зааж, Сумадираднаа “*дээд газар*” хэмээн үгчлэн орчуулцгаасан бол Зая бандида “*Газрын зүгт*” гэж орчуулсан нь магадгүй төвд эхийн зөрүүнээс болсон байж болох юм. Учир нь төвд хэлний “*mchog - чог - дээд*” гэх үгийг “*phyogs - чог - зүг*” гэсэн үгээр эндүүрч бичсэн байх талтай.

<sup>6</sup> Мөн Төвд хэлний **bdud rtsi** хэмээх үгийг монголоор “*рашаан*” гэж орчуулдаг.

<sup>7</sup> Субашидын 242 дугаар ботид төвд хэлний **glegs bam** гэдэг үгийг “*судар*” хэмээн орчуулжээ.

<sup>8</sup> Төвдөөр бас **ri rab** гэдэг.

<sup>9</sup> Раахыг төвдөөр **sgra gcan** гэдэг. Мэргэн гэгээн **gza'**-г “*Раах*” гэж орчуулсан байна.

<sup>10</sup> Норжин. *Монгол хэлний толь*. 2105 дугаар тал.

**Luus.** Төвд хэлний **klu** гэдэг үг монгол хэлэнд орж “лус” болсон бөгөөд гол горхи, цөөрөм, нуур усанд оршигч хүн толгой, могой биетэй нэгэн зүйл амьтан хэмээдэг. Уг төвд үгэнд олон тооны “-с” нөхцөл залгасан хэлбэр.

**Nünčigi. Нүнжиг.** Төвд хэлнээс монгол хэлнээ орсон үг. “*snum 'jug - тос наалдах*” гэсэн утгатай.

#### Бусад харь үгс:

**Nimidi** - Субашидын 46 дугаар бадагт гарах энэ үг төвд эхэд “*Skyu ru ra - жү рү ра*”, санскритаар **āmalaka, rucaka** юм. Түрүү үеийн бичгийн дурсгалуудад тохиолдох бөгөөд түрэг хэлний толь бичигт “*Imiti*” - др.-тюрк. “*разновидность боярышника - долоогоны нэгэн зүйл*” гэжээ. Мэргэн гэгээний эх орчуулга-д цэг тавихгүй зарим үгийн өмнө цэг тавьсан нь нэлээд буй. Сономгара, Дана-гийн гэгээн, Сумадираднаа нар “имиди” гэж, Зая бандида “*жү рү ра*” хэмээн төвдөөр нь галиглаж, Цахар гэвш “*долоогоно*” гэж орчуулжээ.

**Buqar.** Согд гаралтай үг. Эртний бичгийн дурсгалуудад нэлээд тохиолддог. Лам нарын хуран суух орон хийд.

**Yirtinčü.** Ертөнц. Түрэг гаралтай үг. Төвд хэлэнд “*jig rten - жиг дэн - эвдрэхийн шүтээн*” гэнэ.

**Tьgel.** Эх зохиолын 256 дугаар бадагт төвдөөр “*gsos - сой - өсгөх, тэжээх, дэгжээх*” гэсэн утгатай үгийг Мэргэн гэгээн “*түгэл*” гэж орчуулжээ. Уйгур гаралтай үг. *Амар мэнд, амгалан сайн, төгс төгөлдөр* гэсэн утгыг илэрхийлдэг.

**Erlig.** Эрлэг. Уйгур гаралтай үг. Хүчирхэг, эрх хүчтэй хэмээх утгатай. *Нас барсан хүний урьд төрөлдөө үйлдсэн муу үйлийг шүүн шийтгэгч.*<sup>11</sup>

**Lingqu-a.** Лянхуа. Хятад үг. Намаг балчгаас ургадаг боловч шавар огт наалддаггүй хиргүй, маш ариун цэцэг. Өдөр наранд дэлбээлж ургаад шөнө хумьдаг. Төвдөөр “*pad ma - бад ма*”.

**Тетьрь.** *түрэг.* Төвд эхийн “*phyin ci ma log par - чин жи ма лог бар - чанх буруу бус*” хэмээх үгийг “**тетьрь**” гэж орчуулсан бөгөөд уг үг бол *урвах, тонгорох, гэдрэг сөргүү, этгээд буруу, эсрэг тэсрэг*<sup>12</sup> гэсэн утгатай. Түрүү үеийн бичгийн дурсгал болон сурвалжуудад цөөнгүй тохиолддог.

#### Хуучирсан үгс:

**Daryu.** Төвд эхийн 178 дугаар бадагт тохиолдож буй төвдөөр **bag phebs - ваг нэв “санаа амар”** хэмээх үгийг Сономгара “*нут ижилдэх*”, Зая бандида “*сэтгэл тогтон үйлдэх*”, Дана-гийн гэгээн “*нут ижил болж*”, Цахар гэвш “*үнэхээр номхон болох*”, Сумадираднаа “*санаа нийлэн ижилдэж*” хэмээн орчуулцагасан байхад Мэргэн гэгээн “*даруг*” гэж орчуулжээ. Тус үг монгол хэлний “*daru-*” гэсэн язгуураас үүсэлтэй болов уу хэмээн бодно. Даруу төлөв, даруу томоотой гэсэнтэй утга дүйнэ.

**Ünüsterün. Үнэстрүүн:** Үнэртэх гэдгийн эртний хэлбэр. “*Үнэстэх*” гэсэн үйл үгийн үндсэнд монгол хэлний нөхцөлдүүлэн холбох төлөвийн “-рүүн” нөхцөл залгаж бүтсэн үг.

<sup>11</sup> Сүхбаатар. О. (1999) *Монгол хэлний харь үгийн толь*. 229 дүгээр тал. Улаанбаатар.,

<sup>12</sup> Сэцэнцогт. *Монгол үгсийн язгуурын толь*. 1875 дугаар тал. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.,

**Gь...ere -, gü...ire.** Эх зохиолд "амиа хорлох, боож үхэх" гэсэн утгаар тохиолдож буй энэ үгийн уул утга эдүгээ бага зэрэг хуучирч гол төлөв гүжирдэх, гүтгэх гэх утгаар илүүтэй ойлгогддог болжээ. **Gü...ile - хууч.** 1. хорлох, гүжрэх ч гэнэ. 2. хилс хэргээр хэрэг халдаах.

**Qokisu.** Зохиолын 69 дэх бадагт гарч буй төвдөөр "**nog - ног - шил**" хэмээх тус үгийг Сономгара "бөх", Зая бандида "буулга", Дана-гийн гэгээн, Цахар гэвш, Сумадираднаа нар "шил" хэмээн орчуулсан бол Мэргэн гэгээн "хохис" гэж орчуулжээ. "Монгол үгсийн язгуурын толь"-д: Эвэр туурайн хоорондох хохийж хумбайсан эвэрлэг эдийг "хохисун" гэнэ гэж тайлжээ.

**Qayurusun.** 103 дугаар бадагт буй "**sog ma - сог ма - сүрэл**" хэмээх үгийг Мэргэн гэгээн ийн орчуулжээ. Сономгара "өвс", Зая бандида "тарианы иш", Цахар гэвш "муу хог саг", Сумадираднаа "сүрэл" гэж орчуулцгаажээ. **Qayurusun** хэмээх энэ үгийн "y"-ийн өмнөх цэгийг тавиагүй бололтой. Тиймээс уг үг бол "**Gayurusun**" буюу орчин цагийн монгол хэлнээ "гуурс" хэмээх үг болов уу. Сүрэл өвсний хэлбэр байдлаас ингэж нэрлэж буулгасан байх гэж бодно.

**Kedereкь.** Дэмий хэрэн хэсч тэнэж явахыг хэлнэ. Уул хэдрэх. Айл хэдрэх гэх мэт.

**...iluqu.** Зула -: зайлах, дутаах, оргон зулбах, зугтах гэсэн утгатай үг.

**Kubki -.** Юмны овойж товойхыг хэлнэ. Төвд эхийн "**'phyo - чо - хөвөх**" гэсэн үгийг ингэж орчуулсан нь утгын хувьд ойролцоо байна.

**Sьmьlikь.** хууч. "Унтах, бөхөх" гэсэн утгатай үг. Сүүмийх, сүүмэлзэх, сүүтийх зэрэгтэй нэг язгууртай. Сономгара "сөнөмүй", Зая бандида "сөнөх больюу", Цахар гэвш, Сумадираднаа нар "бүр зогсох больюу" гэж орчуулцгаажээ.

**Tanglai šilbūcigsen.** Төвд эхэд "**rkan phug pa - ган нүг ба - тагнай хамгасан**" гэсэн утгатай үг буй. Тиймийн тул "Тагнай шалбачсан" гэх үгийн авиа сэлгэсэн хувилбар гэж үзэж болох юм.

**...ürgei.** Төвд эхийн 236 дугаар бадагт буй төвдөөр '**khрил shing - тил шин** хэмээх энэ үг 14 дүгээр зууны бичгийн дурсгалуудад тохиолддог. Няг охор өргөстэй, нэлээд урт иш юмыг ороож дээш урган алган хэлбэрт оньтой, навч чагтлан ургааж шарангуй ногоон цэцэг дэлгэрээд бөөрөнхий жимсний түрүү суудаг нэг наст буюу олон наст өвслөг ургамал. Жимс нь эмд орно. Ходоодыг сайжруулах үйлдэлтэй. Бас чөдөр өвс ч гэдэг<sup>13</sup> ажээ. Сономгара, Дана-гийн гэгээн нар "зүргэй", Зая бандида "хожуугийн мод"<sup>14</sup>, Цахар гэвш "ороолох өвс", Сумадираднаа "ороолго мод" гэж орчуулцгаажээ.

**Qubiraysan.** Төвд эхийн 110 дугаар бадагт тохиолдох төвдөөр "**skam - гам - хамсан, хуурай**" хэмээх үгийг ийн орчуулжээ. Үүнийг мөшгивөл "Монгол үгсийн язгуурын толь"-д: хууч. **quba - өвс мод, үс юмгүй хожгор халцгай, 2. хатаж өгөрсний байдал гэжээ.**<sup>15</sup> Энэхүү үндэс дээр үйл үг үүсгэх "-р" дагавар болон үйлт нэрийн өнгөрсөн цагийн "-сан" нөхцөл залгаж үүссэн үг ажээ.

**Osqaray-a.** Төвд эхийн 179 дүгээр бадагт буй төвдөөр "**ser ga - сэр га - осгор, хонгил, хөндий**" гэх энэ үгийг Сономгара "хагаранхай", Зая бандида "ан", Дана-гийн гэгээн "гав цав", Цахар гэвш "элэгдэн хагарах", Сумадираднаа "цав гаран хагарьюу" хэмээн орчуулсан буй. Үгийг мөшгивөл "**os**" - 1. Жихүүн хүйтэн буюу жавар салхинд

<sup>13</sup> Норжин. (1999) Монгол хэлний толь. 3044 дүгээр тал.,

<sup>14</sup> Тод үсгийн эхдээ "хожуугийн мод" гэж бичсэн байх бөгөөд "хожуугийн мод" болов уу.

<sup>15</sup> Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. 1120 дугаар тал. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.

нүүр гар, арьс махны саарьтан хагарах. Осгортон ч гэдэг. Нүүр осох. 2. Модны жаахан антах, цавтах. Банз осов. Модон ган осов. **Osqa-a** -: осхоруу, осхор (сэв, арзгар)<sup>16</sup> хэмээхтэй утга тохирно.

**Dotuylayci.** Эх зохиолын 182 дугаар бадагт буй “*gces 'dzin pa - жэй зин ба - эрхэмлэн баригч*” гэх үгийг Сономгара “*дотногохуй*”, Зая бандида “*чухаллан баригч*”, Дана-гийн гэгээн “*дотнологчин*”, Цахар гэвш “*хар бодогч*”, Сумадираднаа “*эдээ хайрладаг*” хэмээн орчуулцгаажээ. Мэргэн гэгээний буулгасан уг үг “*дотнологч*” гэсэн утгатай юм.

**Bysikь.** Төвд эхийн 184 дүгээр бадаг дахь “*'ug pa - үг ба - шар шувуу*” гэх үгийг Мэргэн гэгээн, Дана-гийн гэгээн нар, шар шувууны дуу авиагаар нь “*бүших*” гэж нэрлэн буулгасан бололтой.

**Teniger.** Төвд эхийн 206 дугаар бадагт буй “*mching bu - чин бү - эгэл чулуу*” гэсэн үгийг ингэж орчуулжээ. Энэ үг түрүү үеийн бичгийн дурсгалуудад тохиолдоно. Нэг зүйлийн зөөлөн чулууны нэр ажээ. Үүнийг эрдэмтэн Боссон “*танагар*” хэмээн галиглаад перс хэлний “*тангаар*” ба санскрит хэлний “*танкана*” хэмээх үгнээс гаралтай хэмээн тайлбарлажээ.<sup>17</sup>

**Eber cir.** 210 дугаар бадагт төвдөөр “*zug rngu - сүг ү - эвэршээл*” гэж буй. Хүүч. Өвчин гэмийг хэлнэ. Сономгара “*эвэр*”, Зая бандида, Цахар гэвш, Сумадираднаа нар “*өвчин*”, Дана-гийн гэгээн “*эвэршил*” гэж орчуулцгаажээ.

**Uqar.** Төвд эхийн 119, 287, 317 дугаар бадгуудад нийт гурван удаа тохиолдох төвдөөр “*chu skyar - чу жсар - цахлай*” гэх үгийг Сономгара, Мэргэн гэгээн нар ингэж орчуулсан буй. Толь бичиг, ном сударт нэлээд хэдэн янзаар тайлбарласан байдаг. “*Табан хэлний толь*”-д цахлай, цууцаль хэмээн хадмаллажээ. “*Монгол үгсийн язгуурын толь*”-д: 1. *Махигар гохигор, эртгэр. Модон ухар - шувуу, 2. Махигар хошуутай, загас барьдаг шувуу. Халу мэргэн ч гэнэ*<sup>18</sup> гэж тайлжээ.

**Tuydam.** Хүүч. 298 дугаар бадагт буй төвдөөр “*'byung ba'i tshe na - жүн вий цэ на - болох үед*” хэмээсэн утгатай үгийг Мэргэн гэгээн “*түгдам*” гэж орчуулжээ. Энэ үг бол “*анх, эх, тулгар, сая*” гэсэн утгатай үг юм.

**Byiledbьri.** Төвд хэлний “*bya ba - жа ва - үйл*” хэмээх үгийг ингэж орчуулжээ. Хүүч. “*Үйлдэн хийж байгаа юм, үйлдэх үйл ажил*”-ыг хэлэх бөгөөд эдүгээ энэ утга нь бүдэгрэн хуучирч, улмаар аж ахуйн нэг салбар болох боловсруулах, бүтээх газрыг заасан утгатай болжээ.

**Olhuri.** Төвд хэлний “*'byor ba - жор ва - олз учрал*” хэмээх үгийг ийн орчуулжээ. Үнэ өртөггүй олсон юм, үнэгүй ашиглан хэрэглэх зүйлийг хэлнэ.

**Oyuraqu.** Хүүч. Хаях, гээх, орхих, мартах гэсэн утгатай үг. Хуучны судар ном, сурвалж бичгүүдэд цөөнгүй тохиолддог.

**Сibciyurdan** - төвд хэлний “*'phan zel - нан сэл - гав цав*” хэмээх үгийг Мэргэн гэгээн ийм үгээр оноон орчуулсан байх бөгөөд Сономгара “*хагарсан*”, Зая бандида “*гав цавтай*”, Дана-гийн гэгээн “*хагархай*”, Цахар гэвш, Сумадираднаа нар “*цав*” гэж орчуулжээ. Сibciyurdan гэх үг нь *яг, таг, чавхийтэл* гэсэн утгатай тул үнэт эрдэнэсийг

<sup>16</sup> Дээрх ном. 357 дугаар тал.

<sup>17</sup> *Сайн үгт эрдэнийн сан нэрт шастир.* (1989) 758 дугаар тал, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

<sup>18</sup> Сэцэнцогт. *Монгол үгсийн язгуурын толь.* 396 дугаар тал. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.

л ан цавтай эсэхийг нарийн нягт шинжинэ үү гэхээс бус эгэл ердийн чулууг огт шинжихгүй хэмээсэн утга бүхий төвд эхийн санаатай нийцэх юм.

**yaṣayda...u.** 140 дүгээр бадагт буй төвдөөр “*’gegs te - гэг дэ - хаагдах, хориглох*” гэсэн үг. Сономгара, Зая бандида нар “*боож*”, Дана-гийн гэгээн, Сумадираднаа нар “*гүжрэн*”, Цахар гэвш “*тэвчиж*” гэж орчуулжээ. Гацагдах гэдэг нь *юмны хугацаа бачим, хэмжээ цухал давч, бариу бачуу* гэсэн утгатай үг болно.

**Kimī.** 158 дугаар бадагт байх “*rus pa - рүй ба - яс*” хэмээх үгийг ингэж орчуулжээ. Хим гэдэг бол чөмөг ясны доторх сархиаг нүх болон түүний шим юм.

**Tengsimbi.** 160 дугаар бадагт буй төвд эхийн “*’chor - чор - алдах, гээх*” хэмээх үгийг Мэргэн гэгээн ийм үгээр орчуулан буулгасан бол Сономгара “*алдью*”, Зая бандида “*сул алдах*”, Дана-гийн гэгээн “*үргэлжлэн алдмуй*”, Цахар гэвш “*юмаа бүрэлгэюу*”, Сумадираднаа “*дэмий алдму*” гэж орчуулцгаажээ. Монгол хэлний тайлбар толь бичгүүдэд уг үгийг *дэмий хэсч тэнэн эрэх* хэмээн тайлжээ. *Тэнэх танших хорш.*

**Anamui.** Яр шархын эдгэрэх, шарх анах, ан цавын бүдгэрэх. *Газрын ан анах.*

**Qabiyaqu.** 235 дугаар бадагт гарч буй төвдөөр “*ltos pa - дой ба - түшиглэх, дулдуйдах*” гэсэн үгийг Мэргэн гэгээн ингэж орчуулсан нь утгын хувьд тохирч буй бөгөөд “*хамаа*” гэдэг үгийн эртний хэлбэр юм. “б” авиа “м” болж сэлгэн орчин цагийн монгол хэлэнд “*qatū-a*” болжээ. Харьцаа холбоо, хэрэг холбогдол, садан сүлбээ гэх зэрэг утгатай.

**Yariytayan.** Хууч. Төвдөөр “*ngang gis - ан гуй - аяндаа, зөндөө*” гэх үг. Яваандаа гэсэн утгатай.

**Duran.** Хууч. Хүсэл сонирхол гэсэн утгатай үг. Төвдөөр “*dga’ ba - гаа ва - баяр баясгалан*” гэх үгийг ийн орчуулжээ.

**Nura.** Хууч. Эрэг ганга, гуу жалга зэрэг нурсан газар. Төвдөөр “*g-yang sa - ян са - хавцал*” гэсэн үгийг “*нур газар*” хэмээн орчуулжээ.

**Tamtaraqu.** 387 дугаар бадагт буй төвдөөр “*’dral - дал - цуцлах, хагалах, эвдэх*” хэмээх энэ үгийг Сономгара “*бэлбэрмүй*”, Зая бандида “*цумрах*”, Цахар гэвш “*эвдэрч урсах*”, Сумадираднаа “*садармуй*” гэж өөр өөр үгээр оноон орчуулжээ. “*Тамтрах*” гэдэг үг бол элэгдэж урагдах, эвдрэн сүйдэх гэсэн үндсэн утгатайн дээр хоосорч доройтох, үгүй болох гэсэн шилжсэн утгатай юм.

Дүгнэж хэлбэл, Субашидын монгол орчуулгууд бол 14 дүгээр зуунаас 20 дугаар зуун хүртэлх үеийн монгол хэлний дурсгал болох төдийгүй монгол хэл аялгуунуудын үгийн сангийн онцлогийг тусгаснаараа эрдэм шинжилгээ, судалгааны чухал ач холбогдолтой юм. Эдгээрээс бид Өвөр Монголын Урад хошууны Мэргэн гэгээн хэмээн алдаршсан Лувсандамбийжалцаны орчуулгыг онцлон, цөөвтөр үгийг сонгон бусад орчуулгатай харьцуулан үзэж тайлбарлалаа.

## НОМ ЗҮЙ

### Монгол хэлээр:

1. Бүрнээ Д, Энхтөр Д. (2001) *Төвд монгол толь*. Улаанбаатар.,
2. Бүрнээ Д, Энхтөр Д. (2004) *Монголын бурханы шашины түүхэн сурвалж*. Улаанбаатар.,
3. Дамбажав И. (2006) *Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгний дээж*. Улаанбаатар.,
4. Дамдинсүрэн Ц, Лувсандэндэв А. (1982) *Орос монгол толь*. Улаанбаатар.,
5. *Монголын уран зохиолын тойм*. (1977) 2 дугаар боть. Улаанбаатар.,
6. Норжин. (1999) *Монгол хэлний толь*. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.,
7. *Сайн үгт эрдэнийн сан нэрт шастир*. (1989) Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.,
8. Сүхбаатар О. (1999) *Монгол хэлний харь үгийн толь*. Улаанбаатар.,
9. Сэцэнцогт. (1988) *Монгол үгсийн язгуурын толь*. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.,
10. *Хорин наймт тайлбар толь*. (1994) Намжилмаа эмхлэв. Өвөр Монгол ардын хэвлэлийн хороо.,
11. *Хятад - монгол толь*. (2005) Үндэстний хэвлэлийн хороо. Бээжин.,
12. Цэвэл Я. (1966) *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.,
13. *Шинэ монгол - хятад толь*. (2002) Бээжин.,
14. *Эрдэнийн сан нэрт сайн үгт шастир*. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны орчуулга. Бээжин барын судар. 78 хуудас.,

### Орос хэлээр:

1. *Древнетюркский словарь*. (1969) Ленинград.,
2. Рерих Ю. Н. (1983) *Tibetan-Russian-English dictionary with Sanskrit parallels*. USSR. Academy of Sciences Institute of Oriental Studies. Moscow.,

### Англи хэлээр:

1. James Bosson. (1969) *A Treasury of Aphoristic Jewels; the Subhasitaratnanidhi of Sa Skya Pandita and Mongolian*, - Uralic and Altaic series, Vol.92, Indiana Univer., Bloomington.,
2. Төмөртоого Д. (2006) *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI centuries) // Introduction, Transcription and Bibliography Linguistics Monographs Series A 11], Academia Sinica, Institute of Linguistics, 726 pp, Taipei, Taiwan.,*

## SUMMARY

Mongolian translation of Subhashita by Mergen geegen Luvsandambijaltsan should be considered as one of the most valuable monuments of the Mongolian language in the 18<sup>th</sup> century. Unfortunately, the translation has not been studied as well as it should. The author has attempted to study and pursue some words while dividing the work into the following parts: Sanskrit words, Tibetan words, loan words and archaic words.